



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 01 сарын 24 өдөр

Дугаар A/10

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2019 оны “Эрх шилжүүлэх тухай” А/527 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар зам засвар, арчлалтын газар” ОНӨААТҮГ-т “Машин, механизм нийлүүлэх” УБЗЗАГ/ММН-2019 дугаартай гэрээт ажлын гүйцэтгэгчээр сонгон шалгарсан “Вагнер Ази тоног төхөөрөмж” ХХК-аас нийлүүлэх хөрөнгийг хүлээн авах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор байгуулсугай.

2. “Улаанбаатар зам засвар, арчлалтын газар” ОНӨААТҮГ-т нийлүүлэгдэж буй машин, механизмыг тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтын дагуу хүлээн авах ажлыг зохион байгуулахыг Ажлын хэсэг /С.Ариунжаргал/-т үүрэг болгосугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг орлогч дарга Д.Рэнцэнбямбад даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
газрын даргын 2020 оны.....01.....сарын
24..өдрийн ..21/10.....тушаалын хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн
ахлагч

С.Ариунжаргал /Нийслэлийн Өмчийн ашиглалт,
удирдлагын газрын Өмчийн төлөөлөл,
менежментийн хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч/

Гишүүд:

Д.Ариунболд /“Улаанбаатар зам засвар, арчлалтын
газар” ОНӨААТҮГ-ын Үйл ажиллагаа, төлөвлөлтийн
хэлтсийн дарга/

Б.Баатархүү /“Улаанбаатар зам засвар, арчлалтын
газар” ОНӨААТҮГ-ын ерөнхий инженер/

Т.Оюунсүвд /Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
газрын Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн
мэргэжилтэн/

Нарийн бичгийн
дарга:

М.Энхболд /Нийслэлийн Өмчийн ашиглалт,
удирдлагын газрын Өмчийн төлөөлөл,
менежментийн хэлтсийн ахлах мэргэжилтэн/